



Embassy of the
Republic of Korea
in Mongolia

POOMSAE



TAEKWONDO CHAMPIONSHIP

Ambassador Cup

2024

30, 31 AUG & 1 SEP 2024
ULAANBAATAR, MONGOLIA



УДИРДАМЖ

ЭЛЧИН САЙДЫН ЦОМ 2024

ТАЕКВОНДОГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

1. ДЭМЖИГЧ	БНСУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ
ХАЯГ:	Хан-Уул дүүрэг-15, Махатма Гандийн гудамж-39, Улаанбаатар-17011
УТАС:	(976) 7007-1020
ФАКС:	(976) 7007-1021
ВЭБ:	www.overseas.mofa.go.kr
2. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:	МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО
ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 7015-5500
ИМЭЙЛ:	mongoliatekwondo@gmail.com
ВЭБ:	www.mongol-taekwondo.com
3. ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО:	
ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 8619-0073
СОШИАЛ:	https://www.facebook.com/БичигХэрэг
ВЭБ:	https://www.facebook.com/MongolTaekwondo
4. БАЙРШИЛ:	СПОРТЫН ТӨВ ОРДОН Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, А заал
5. ОГНОО:	2024 оны 8 сарын 30, 31, 9 сарын 1
6. ШААРДЛАГА:	
Тэмцээнд оролцогч тамирчдад Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.	
ШААРДЛАГА 1:	Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна, зөвхөн тэр бүсээ бүсэлж тухайн бүсний ангилалдаа өрсөлдөнө.
ШААРДЛАГА 2:	Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.



7. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

i. Тэмцээнд оролцогчид хүйс, насаар хязгаарлагдахгүй бол дээд тал нь хоёр ангилалд өрсөлдөх боломжтой.

II. Насны хувьд:

- Бага нас: 8-9 нас
- Бага нас: 10-11 нас
- Өсвөр үе: 12-14 нас
- Залуучууд: 15-17 нас
- Насанд хүрэгч: 18-аас дээш нас
- Насыг сараар бус жилээр тооцно. Жишээлбэл: Залуучуудын ангилалд өрсөлдөх тамирчин нь 2007.1.1-2009.12.31 хооронд төрсөн байна.

III. Бүсний ангилал:

- А ангилалд хар бүс, күккивоны дантай тамирчид
- В ангилалд хөх, улаан бүстэй тамирчид
- С ангилалд ногоон бүстэй тамирчид
- D ангилалд шар бүстэй тамирчид тус тус оролцох эрхтэй.
- Чөлөөт пүмсэ төрөлд насны ангилал байх боловч бүсний ангилалгүй өрсөлдөнө.
- Насанд хүрэгчдийн элит ангилалд зөвхөн хар бүстэй тамирчид өрсөлдөнө
- Насанд хүрэгчдийн сонирхогчдын ангилалд бүсний ангилалгүй өрсөлдөнө

8. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУГАЦАА:

I. Үндсэн пүмсэ: 90 секунд хүртэл

II. Чөлөөт пүмсэ: 90-100 секундын хооронд

III. Завсарлага: Эхний пүмсэ болон хоёр дахь пүмсэ хоорондын зай хамгийн багадаа 30 секунд

9. ГҮЙЦЭТГЭХ ДАСГАЛ:

Үндсэн пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Эрэгтэй баг (3 эрэгтэй)
Эмэгтэй баг (3 эмэгтэй)
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)

Чөлөөт пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан



Холимог хос, багийн ангилалд зөвхөн өөрийн бүсний ангиллын тамирчин, тамирчидтай хамтарна.

/Жишээлбэл: С ангиллын тамирчин А ангиллын тамирчинтай нэг баг эсвэл хос болж болохгүй/

Үндсэн пүмсэ: Ганцаарчилсан (эрэгтэй, эмэгтэй), Холимог хос, баг

Нас	Ангилал	Урьдчилсан шат	Шигшээ шат
Бага нас	А ангилал	Таекүк 6 жан	Таекүк 7, 8 жан
	В ангилал	Таекүк 3 жан	Таекүк 4, 5 жан
Өсвөр үе	С ангилал	Таекүк 2 жан	Таекүк 3, 4 жан
	Д ангилал	Таекүк 1 жан	Таекүк 2 жан
Залуучууд	А ангилал	Таекүк 7 жан	Таекүк 8 жан, Корёо
	В ангилал	Таекүк 5 жан	Таекүк 6, 7 жан
	С ангилал	Таекүк 2 жан	Таекүк 3, 4 жан
Насанд хүрэгч /Элит ангилал/	А ангилал	Корёо	Кимган, Тебек
Насанд хүрэгч /сонирхогч/	Бүсний ангилалгүй	Таекүк 1 жан	Таекүк 2, 3 жан

Чөлөөт пүмсэ:

Тамирчид таеквондогийн техник дээр тулгуурлан хөгжим, бүжиг дэглэлт бүхий чөлөөт пүмсэ гүйцэтгэнэ. Гүйцэтгэх техникүүд нь таеквондогийн хүрээнд байх ёстой. (суултууд: Дидкүби соги, Хакдари соги, Боем Соги, үсэрч: ёбчаги, степ, 180, 360 градус эргэлттэй өшиглөлт)

Өөрсдийн зохиосон пүмсэг 90-100 секундын хугацаанд хөгжмийн аянд хийж гүйцэтгэнэ. Заасан хугацаанаас бага хугацаанд эсвэл хугацаа хэтэрвэл оноо хасагдана. Заавал хийх техникүүдийг оруулсан байх бөгөөд уран сэтгэмж, хөдөлгөөний эвсэл, аяны зохицол, дэвжээ эзэмшилт болон өндөр градустай техникийг харж дүгнэнэ.

10. БАГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- I. Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- II. Бүртгэлийн хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй!
- III. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.
- IV. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх болон явах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд онцгой хандуулах нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг юм.



11. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болох www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.
- II. Бүртгэлийн системд тамирчдыг бүртгүүлэхдээ сүүлийн 6 сард авахуулсан цээж зургийг ашиглана.
- III. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

12. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. **Энгийн бүртгэл:** 2024 оны 8 сарын 8-наас 22-ны 23:59 цаг хүртэл
Нэг төрөлд оролцох тамирчны дэвжээний төлбөр:
 - Улаанбаатар хотын тамирчид 50.000 (тавин мянга) төгрөг,
 - Хөдөө орон нутгийн тамирчид:
 - Улаанбаатар хотоос 1000 км дотогш 40.000 (дөчин мянган) төгрөг
 - Улаанбаатар хотоос 1000 км гадагш Үнэ төлбөргүй (нэг төрөлд орох бол)
 - Хоёр төрөлд оролцох тамирчны хувьд дэвжээний төлбөр дээр 10.000 (арван мянга) төгрөг нэмэгдэнэ.
- II. **Хоцорсон бүртгэл:** 8 сарын 22-ны 23:59 цагаас 8 сарын 26-ны 18:00 цаг хүртэлх бүртгэлд тамирчин тус бүр 10.000₮ (арван мянган төгрөг) нэмэгдэнэ.
- III. 2024 оны 8 сарын 26-ны 18:00 цагаас хойш ямар ч тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулахгүй.

13. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- I. Хувь тамирчин:
Дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явуулна.

1-Р БАЙР: АЛТАН МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

2-Р БАЙР: МӨНГӨН МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

3-Р БАЙР: ХҮРЭЛ МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

3-Р БАЙР: ХҮРЭЛ МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

- II. Баг:

- Багийн дүнг зөвхөн А ангилалд тооцох ба медалийн чанараар эрэгтэй болон эмэгтэй ангилалд тус бүр эхний гурван байр эзэлсэн багуудад цом, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.
- Насанд хүрэгчдийн сонирхогчийн ангилал болон бүх насны чөлөөт пүмсэ төрөлд медаль хүртсэн тамирчдын медаль багийн дүнд тооцогдохгүй.



III. Шилдэг дасгалжуулагч:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 дасгалжуулагчийг тус тус шалгаруулан шагнана.

IV. Шилдэг тамирчин:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 тамирчинг тус тус шалгаруулан шагнана.

V. Шилдэг шүүгч:

Тэмцээний шилдэг шүүгчээр 1 шүүгчийг шалгаруулан шагнаж урамшуулна.

VI. Өсөх ирээдүйтэй тамирчин:

B, C, D ангилал тус бүрээс 1 тамирчин шалгаруулж өсөх ирээдүйтэй тамирчин тодруулан шагнана.

14. Өмсгөл

А ангилалд өрсөлдөх тамирчин нь пүмсэ тобог өмсөх шаардлагатай.

Монгол улсад хэрэглэгдэх таеквондогийн өмсгөлийн стандарт



ПҮМСЭ

Пүмсэ буюу тоот дасгалын тамирчид Ү төрлийн задгай энгэртэй өмсгөл өмсөнө. 15 хүртэлх насны тамирчид хүйснээс хамааран улаан болон хөх өнгийн өмд, улаан, хар судал бүхий энгэрийн эмжээр бүхий дээд өмсгөл өмсөнө. Өндөр дан (Хар бүс 7-р дан болон түүнээс дээш) болон ахмад настай мастерууд ердийн цагаан өнгөний оронд алтан шар өнгийн өмсгөл өмсөх эрхтэй байдаг байна.



ГҮП, ПҮҮМ ЗЭРЭГ

15 хүртэлх насны тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хөх өнгө
Эмэгтэй: Улаан өнгө



ДАН ЗЭРЭГ

16 ба түүнээс дээш настай хар бүстэй тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хар өнгө
Эмэгтэй: Саарал өнгө



МАСТЕР

Хар бүс 7-р дан болон түүнээс дээш дантай мастерууд. Мөн түүнчлэн ахмад настай мастер тамирчид Алтан шар өнгийн өмсгөл өмсөнө.

- B, C ангилалд өрсөлдөх тамирчин ердийн тулааны тобог өмсөн оролцож болох хэдий ч Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана.
- Тэмцээний өмсгөлийн стандарт



15. Багийн ахлагчдын уулзалт болон сугалаа

- I. Багийн ахлагч нар тэмцээн эхлэхээс 1 хоногийн өмнө хуралдана.
- II. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.
- III. Тэмцээний дэлгэрэнгүй хуваарийг багийн ахлагчдын уулзалтаар танилцуулна
- IV. Сугалааг тэмцээн эхлэхийн өмнө <https://www.facebook.com/MongolTaekwondo> олон нийтийн хуудаст байршуулна.

16. Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

- I. Дасгалжуулагч нь Монголын таеквондогийн холбооны В, С зэрэг авсан эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчныг дэвжээнд авч гарах эрхтэй.
- II. Хагас шигшээ болон шигшээ тоглолтод оролцох дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай.
- III. Дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -